



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 86.

Шивээговь сум

“Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын
тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1 дэх
заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох
журам”-ыг хавсралт-1-ээр баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд
хагас, бүтэн жилээр тайлагнаж байхыг засаг дарга /С.Ягаанцэцэг/-т үүрэг
болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭБАТ

Сумын ИТХТ-ийн 2019 оны 11 дүгээр
сарын 05-ны өдрийн № 86 дугаар
тогтоолын хавсралт

Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхэлж байгаа дэлгүүр, бизнес эрхлэгчид, шинээр тамхи худалдах иргэдийг дэмжих, өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг нь тодорхойлох, үйл ажиллагаанд нь хяналт тавихад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхлэж буй иргэд, аж ахуй нэгж, дэлгүүрүүд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Журам хэрэгжүүлэх ажлыг сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн дэсэг хамтран зохион байгуулна.

Хоёр. Сумын Засаг даргын эрх, үүрэг

2.1. Тамхины хяналтын тухай хуулийн 7.3-т тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгоно гэж заасны дагуу тус сумын нутаг дэвсгэрт худалдаа эрхлэх ажлын байрны эмх цэгц, эрүүл ахуйн шаардлага хангасан барилга байгууламж бүхий тохирлын гэрчилгээ, ажлын байрны дүгнэлт, галын аюулгүй байдлын дүгнэлттэй дэлгүүр, ААНэгж, бизнес эрхлэгчдэд тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг олгоно.

2.2. Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгоно. Худалдаа эрхлэх явцаа зөрчил гаргаагүй тохиолдолд дахин зөвшөөрөл олгоно.

2.3. Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээг Засаг даргын захирамжийн дагуу ажлын 5 хоногт багтаан шинэчлэн байгууллага бүрээр хувийн эрэг бүрдүүлэн гаргаж олгоно.

Гурав. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг

3.1. Худалдаа явуулах шаардлага хангасан иргэд хүсэлтээ сумын Засаг даргын Тамгын газарт гаргана.

3.2. Тамхины худалдаа явуулж буй иргэд нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандарт, сумын нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, төрийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийг чанд биелүүлнэ.

3.3. Тамхи худалдаалах иргэд нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан эрүүл мэндийн дэвтэртэй байна.

3.4. Худалдаа явуулж буй иргэн нь орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаж ажиллах, хог хаягдал гаргасаны төлбөрийг холбогдох журмын дагуу төлж байна.

3.5. Тамхи худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, ААНэгж нь эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгавар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дөрөв. Хураамж

4.1. Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхлэх иргэн, ААНэгж нь тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийн хураамж 250000 /хоёр зуун тавин мянга/ төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлнэ.

Тав. Тамхи худалдан борлуулахад хориглох зүйл

5.1. 21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах

5.2. Тамхийг ширхэглэн худалдах, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдах

5.3. Тамхины автомат машин ажиллуулах

5.4. Тамхины борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа зохион байгуулах, сугалаа гаргах

5.5. Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах

5.6. Интернетээр тамхи худалдах

5.7. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг болон дотуур байрнаас 500 метрийн дотор тамхи худалдах

5.8. Баар, цэнгээний газарт тамхи худалдах

Зургаа. Хяналт

6.1. Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхэлж буй иргэд, дэлгүүр, ААН-ийн үйл ажиллагаанд сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, тухайн багийн Засаг дарга нар, Цагдаагийн хэсэг, эрх бүхий албан тушаалтан хяналт тавина.

6.2. Тамхины худалдаа явуулж буй талаарх мэдээлэл, иргэдийн гомдол мэдээлэл, хяналтын дагуу хяналт тавьж, асуудлыг шат шатандаа шийдвэрлэн ажиллана.

Долоо. Хариуцлага

7.1. Энэхүү журмын 3 болон 5 дугаар зүйлийн заалтуудыг зөрчсөн тохиолдолд; Монгол улсын "Эрүүл ахуйн тухай" "Тамхины хяналтын тухай", "Зөрчлийн тухай" хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу сумын Цагдаагийн хэсэг, эрх бүхий албан тушаалтан, тухайн багийн Засаг дарга нар хариуцлага тооцно.

Мөн хугацаанаас нь өмнө Засаг дарга тамхи худалдаалах тусгай зөвшөөрөлийг авчирч ажиллана.